

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2009 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2010.03.25

Архангай

амйаг

Зорилт, арга хэмжээ	Биелэлт
Зорилт 5. Хүн амыг эрүүл хүнсээр бүрэн хангах зорилгоор мал аж ахуй газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, боловсруулалтыг нэмэгдүүлж, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангах бодлого баримтлана.	
<p>5.3. Өрхийн аж ахуйгаас бэлтгэсэн илүүдэл төмс , хүнсний ногоо, мах, сүү, цагаан идээ борлуулах , татвар, түрээсийн төлбөргүй хүнсний зах, салбар, цэгүүдийг аймаг, сумын төв, нийслэлийн хороодод байгуулж ажиллуулах</p>	<p>2009 онд аймгийн хэмжээнд 5000 шахам өрхийн үйлдвэрлэсэн 15000 л сүү, 8000 кг цагаан идээ, 2800 гаруй иргэн, аж ахуйн нэгж 770.5 га талбайд төмс, хүнсний ногоо тариалж 4386 тн ургац хураан авч зах зээл худалдан борлуулах ажлыг 19 төв сууринд 30 гаруй зах, цэг, салбараар дамжуулан түрээсийн төлбөргүйгээр худалдан борлуулах ажлыг шат шатны засаг дарга нар зохион байгуулан ажиллахын зэрэгцээ бүтээгдэхүүнээ сурталчилах, чанар, өнгө үзэмжийг нь сайжруулах, түншлэл тогтоох зах зээлд гаргахад нь туслаж үзэсгэлэн худалдааг орон нутагт болон бүсийн төв, Улаанбаатар хотод зохион байгуулан оролцуулж байна.</p> <p align="right">Хэрэгжих шатанд- 90%</p>
<p>5.4. Нийслэл болон орон нутгийн томоохон хотуудад экологийн цэвэр сүү, цагаан идээ, мал болон гахай тахианы мах махан бүтээгдэхүүн өндөгний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлж, “Сүү” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж эхлэх</p>	<p>“Сүү” аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан батлуулахаар бэлтгэж байна.</p> <p align="right">Хэрэгжих шатанд- 30%</p>
Зорилт 11. Агаар ус, хөрсний бохирдол, орчны доройтлыг бууруулах, хянах тогтолцоог боловсронгуй болгоно	
<p>11.5. Газрын нэгдсэн төлөвлөгөөг УИХ-аар батлуулж, нийслэл аймгийн төв болон төвлөрсөн суурингийн гэр хорооллыг барилгажуулахаас бусад газруудыг зөвхөн нээлттэй дуудлага худалдаагаар</p>	<p>Шинээр газар эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу ил тод нээлттэй зохион байгуулснаар 15 сумын нутаг дэвсгэрт 42 удаагийн дуудлага худалдаа явуулж, дуудлага худалдааны ялагчидтай байгуулсан</p>

худалдах тогтолцоонд шилжих	гэрээний үүргээ биелүүлсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагад үйлдвэрлэл, үйлчилгээ, үр тариа, төмс хүнсний ногооны зориулалтаар нийт 126.1 га газрын газар эзэмших эрхийн үнийг 53.0 сая төгрөгөөр худалдаж орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна. Биелэсэн – 100%
11.7. Говь ,хээр, цөлжилт ихээр явагдаж байгаа бүс нутгуудад усны нөөцийг нэмэгдүүлэх, мод бут, сөөг тарьж ургуулах ажлын эрчимжүүлэх үр дүнг сайжруулан аарчилгаа хамгаалалтыг сайжруулах	Цөлжилттэй тэмцэх аяныг жил бүр зохион байгуулж, аймгийн хэмжээнд 43 нөхөрлөл байгуулан сургалт хийв. Нөхөрлөлүүд навчит мод үржүүлэх ажлыг хийж байна. Хашаатын Сайн түрүү нөхөрлөл 1800 навчит модыг үрээр үржүүлж байна. Мөн Өгийнуур, Хотонт сум улиас зэрэг намчит модыг мөчраар үржүүлж байна. Аймгийн БОАЖГ-ын дэргэд 5 га газрыг хашиж усалгаатай нөхцөлд шар хуайс, улиасыг үрээр үржүүлж байна. Эндээс Өгийнуур, Хотонт, Хашаат сумдыг дэмжих бодлого барьж байна. Ойжуулалтын ажлыг жил дараалан нэмэгдүүлж энэ онд 57,8 сая төгрөгөөр 285 га-д ойжуулалт хийв, Хасу мандал, Ар-Шинэс, Ар-Тээл, Тэлээ таван хайрхан, Цогт-Уяанга зэрэг аж ахуйн нэгжүүд өөрийн хөрөнгөөр 80 шахам га-д байгалийн сэргээн ургалтыг дэмжих ажлыг хийв. Биелэсэн – 100%
11.7.1. Говь хээрийн бүсэд усан сан хөв байгуулах, мод бут сөөг тарьж ургуулах ажлын үр дүнг сайжруулан арчилгаа, хамгаалалтыг сайжруулах	Төвшрүүлэх суманд ХЯБХ-ийн санхүүжилтээр 48.0 сая төгрөгийн хөв цөөрөм байгуулах ажлыг хийж дуусган ажлын комисст хүлээлгэн өгсөн болно. Энэ ажлыг бүх сумдад хийх судалгааны ажил хийгдэж байна. Хэрэгжих шатанд- 70%
11.8. Говь,хээрийн цөлжилт ихээр явагдаж байгаа бүсүүдэд баянбүрд үүсгэх, худаг, ус гаргах, усжуулах бүхий л санал санаачилгыг дэмжиж, “Ус”хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх , хөдөөгийн баг бүрт сүүлийн үеийн дэвшилтэт технологийг ашиглан шинээр 1 худаг нэмж гаргах ажлыг эхлүүлэх.	Баг бүрт сүүлийн үеийн дэвшилтэт технологийг ашиглан шинээр худаг гаргах ажлыг ээлж дараагаар хийж байна. Энэ бодлогын хүрээнд бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор инженерийн хийцтэй худаг 2008 онд 16 багт, 2009 онд 15 багт шинээр гаргаж ашиглалтанд өгөв. Хэрэгжих шатанд- 90%

Зорилт 15. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн амд тэгш, хүртээмжтэй чанартай үзүүлж, элдэв өвчлөлийг эрс бууруулж, дундаж наслалтыг нэмэгдүүлэх, хүн амын өсөлтийг дэмжихэд чиглүүлнэ	
15.13. Хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах зорилгоор бүсийн болон аймаг, нийслэлд шүдний кабинет байгуулах ажлыг дэмжиж, хэрэгжүүлэх	<p>2009 онд аймгийн төвд 40 орны хүчин чадалтай Хүүхдийн эмнэлгийн барилгыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 500 сая төгрөгөөр бариулж ашиглалтанд хүлээн авлаа.</p> <p>Хүүхдийн эмнэлэг дотор хүүхдийн шүдний иж бүрэн тоног төхөөрөмжтэй Хүүхдийн шүдний кабинетийг ашиглалтанд орууллаа.</p> <p style="text-align: right;">Биелэсэн –</p> <p>100%</p>
15.17. Нийтийн биеийн тамир, спортын материаллаг баазыг өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх, нийтийн биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлогыг батлуулж, хэрэгжүүлж эхлэх	<p>Аймгийн Биеийн тамир Спортын газарт 1,8 сая төгрөгийн үнэ бүхий биеийн тамирын техник хэрэгслээр хангасан байна. Өгийнуур сумын сургуулийн спортын заалыг шинээр барьж ашиглалтанд орууллаа.</p> <p>Биеийн тамир спортыг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан аймгийн Засаг даргын зөвөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар бэлтгэлийг хангаад байна.</p> <p style="text-align: right;">Хэрэгжих шатанд- 90%</p>

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР